



Монголын Хуульчдын холбооны
10 жилийн ой



Чингэлтэй дүүргийн шүүхийн 30 жилийн ой

ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХОЛБООНЫ 10 ЖИЛИЙН ОЙ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН 30 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БУЙ “ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУЛГАМДСАН АСУУДАЛ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Монголын Хуульчдын Холбооны 10 жилийн ой, Чингэлтэй дүүргийн шүүхийн 30 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хамтран зохион байгуулах гэж байна.

Нэг. Хурлын зорилго

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал, шүүхийн практикт хэрэгжиж буй байдлын талаар хэлэлцэх, шийдэл эрэлхийлэх, судалгааны ажлын үр дүн, санал дүгнэлтийг хэлэлцэж шинэ санаа, санаачлагыг дэмжих замаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг хууль тогтоогчид хүргүүлэх, шийдвэрлүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Хэлэлцэх чиглэл

- Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онол, арга зүй тулгамдсан асуудал, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал дүгнэлт

Гурав. Хэлэлцүүлэгт оролцогч

- Монгол Улсын Дээд шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд, прокурор, өмгөөлөгч, хууль зүйн их, дээд сургуулийн багш, судлаач Монголын Хуульчдын холбоо, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөлөл, судлаачид

Дөрөв. Илтгэл хүлээн авах

- Илтгэлийг 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн дотор бүрэн эхээр нь pdf форматаар khostsetseg@mglbar.mn имэйл хаягаар ирүүлнэ үү
- Шалгарсан илтгэлийг хэлэлцүүлэх бөгөөд шалгарсан илтгэлийг ppt форматаар Монголын хуульчдын холбооноос гаргасан загварын дагуу слайдыг бэлдэж 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн дотор хүлээн авна.



Монголын Хуульчдын холбооны
10 жилийн ой



Чингэлтэй дүүргийн шүүхийн 30 жилийн ой

Тав. Илтгэлийн бичиглэл боловсруулалтын шалгуур

- Цаасны хэмжээ А4, цаасны зүүн талаас 3см, дээд, доод талаас тус бүр 2см, баруун талаас 1.15см
- Мөр хоорондын зай single
- Үсгийн фонт Arial
- Үсгийн өндөр үндсэн бичвэрт 12pt, ишлэл 9pt
- Хүснэгт, зураг тус бүр нэр, дугаартай байх
- Хуудасны тоо илтгэл 15 хуудаснаас хэтрэхгүй байх
- Ишлэл, зүүлт, ном зүйг хавсаргасан байх

Зургаа. Илтгэлд тавигдах агуулгын шалгуур

- Онол арга зүйн асуудлыг хөндсөн
- Шинэ санаа, оновчтой шийдлийг эрэлхийлсэн
- Логик дэс дараалалтай
- Шинжлэх ухааны үндэслэлтэй
- Шийдвэрлэх асуудлын хүрээг зөв тодорхойлсон
- Үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн
- Мэдээллийн эх сурвалжийг эшилсэн
- Судалгааны арга зүйгээ тодорхойлсон

Хэлэлцүүлэгт хэлэлцэгдсэн илтгэлийг эмхтгэж хэвлүүлнэ.

---o0o---